

**БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ САЙД,
УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН САЙДЫН
ХАМТАРСАН ТУШААЛ**

2023 оны 10 сарын 30 өдөр

Дугаар A/1464, A/320

Улаанбаатар хот

**Хүнд үйлдвэрлэлийн технологийн түвшний
үнэлгээ хийх эрх олгох тухай**

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Технологи дамжуулах тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2 дахь заалт, Боловсрол, шинжлэх ухааны сайд, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны А/381, А/274, А/313 дугаар хамтарсан тушаалаар баталсан “Хүнд болон хөнгөн үйлдвэрлэлийн технологийн түвшний үнэлгээ хийх байгууллагад эрх олгох журам”-ын 3.1 дэх хэсэг, Боловсрол, шинжлэх ухааны сайд, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2023 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн А/235, А/200 дугаар хамтарсан тушаалаар байгуулагдсан Хүнд болон хөнгөн үйлдвэрлэлийн технологийн түвшний үнэлгээ хийх байгууллагад эрх олгох, цуцлахад зөвлөмж, санал, дүгнэлт гаргах, хяналт тавих чиг үүрэг бүхий орон тооны бус зөвлөлийн 2023 оны ТТЭ-2023-01, ТТЭ-2023-02 дугаар дүгнэлтийг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Шинжлэх ухааны академийн Хими, химийн технологийн хүрээлэн (РД:9096116), Шинжлэх ухаан, технологийн их сургууль (РД:9087087) (Геологи, уул уурхайн сургууль, Механик, тээврийн сургууль, Уул уурхайн хүрээлэн)-д хүнд үйлдвэрлэлийн технологийн түвшний үнэлгээ хийх эрхийг 3 жилийн хугацаатай олгосугай.

2. Хүнд болон хөнгөн үйлдвэрлэлийн технологийн түвшний үнэлгээ хийх байгууллагад эрх олгох журам болон бусад холбогдох хууль тогтоомжийн хүрээнд үйл ажиллагаа явуулахыг Шинжлэх ухааны академийн Хими, химийн технологийн хүрээлэн (Л.Жаргалсайхан), Шинжлэх ухаан, технологийн их сургууль (Т.Намнан)-д тус тус даалгасугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Магнайсүрэн, Боловсрол, шинжлэх ухааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Л.Цэдэвсүрэн нарт тус тус даалгасугай.

**БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ
УХААНЫ САЙД**

Л.ЭНХ-АМГАЛАН

**УУЛ УУРХАЙ, ХҮНД
ҮЙЛДВЭРИЙН САЙД**

Ж.ГАНБААТАР